

## Хөдөөгийн хөгжил ба ядуурал: Ядуурлын эзэн ба шалтгааны тухайд ...

*Ж.Эрдэнэцогт, магистр, Эрин үе төв ТББ-ын судлаач*

Монголчууд бид ардчилсан нийгмийн тогтолцоо, зах зээлийн эдийн засгийн зарчмыг сонгон авахдаа цаашдын хөгжил дэвшлийнхээ үндэс суурийг тавьж байна хэмээн ойлгож, уг сонголтоо хийж, улмаар “Үндсэн хууль”-аараа баталгаажуулсан билээ.

Бид бүгдийн ярьж байгаа тэр хөгжил гэдэг нь үнэн хэрэгтээ тухайн улс орон, орон нутагт оршин суугаа ард түмэн, олон нийтийн хөгжлийн асуудал хэмээн ойлгож болно. Хөгжлийн үйл явцыг түүхэн талаас нь авч үзвэл уламжлалт ба орчин үеийн гэж ангилж болно юм. Гэхдээ өнөөгийн нийгмийн нэг тод чанар нь хот, хөдөөгийн гүн гүүзгий ялгаанд оршиж байна. Улс төрийн болон эдийн засгийн амьдрал, үйл явц голдуу нэг, хоёр эсвэл гуравхан хотын дунд өрнөж, үйл явц төвлөрдөг.

Судалгаанаас үзэхэд сүүлийн жилүүдэд хөдөөгийн хөгжил хэр зэрэг дээшилсэн гэдгийг судлаач С.Бат-Оюун “Хөгжлийн албан ёсны тусламж-хөдөөд” бодлогын судалгааг хийхдээ “... хөдөөгийн хөгжил ба түүнийг тодорхойлох боломж тун бага, тодруулах нөхцөл ч алга. Учир нь хөгжилд чиглэгдэж байгаа төсөл хөтөлбөрүүдийн нилээд нь улс орныг бүхэлд нь хамарсан макро эдийн засгийн бүтцийн өөрчлөлт хийх, тогтолцоог шинэчлэх чиглэлтэй байгаагаас хөдөөд чиглэсэн хөгжлийн асуудал анхаарлын төвд яригдахгүй бас хөгжихгүй байна” гэж үзсэн байна. Сонин тодорхойлолт байгаа биз! Манай орны нийт хүн амын тавны хоёр хувь нь оршин суудаг хөдөөд хөгжил гээд тодорхойлчихоор зүйл алга, бас боломжгүй байна гэсэн судлаачын дүгнэлт нэн анхаарууштай асуудал. Мэдээж энэ асуудлыг улс төрийн хөгжлийн тухай олон арван онолын тайлал, толгой эргэм тоон мэдээллээс цааш нь үргэлжлүүлж болох ч энэ удаад энгийн бодит байдлаар асуудалд хандахыг оролдсон болно.

Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж, нэгдэл, сангийн аж ахуй задран үгүй болж, малыг малчдад хувьчилснаар эдийн засгийн чадавхи сул, амиа аргацаасан 190 гаруй мянган хөдөөгийн хот айл үүсч бий болов. Энэхүү шилжилтийн үе эхлээд 17 жил болж байгаа ч хөдөөгийн иргэд зах зээлийн шинэ нөхцөлд хэрхэн зохицон ажиллаж, амьдарч байгаа сэтгэл зүйн болоод эдийн засгийн чадавхи хэрхэн өөрчлөгдөж байгаа нь ихээхэн сонирхол татаж байна.

Цагаан морин жилийн хувьсгалаас хойш буюу хөгжлийн эхний жилүүдэд 21-р зууны монголын хөдөөгийн иргэд, малчид чухам л түүхийн 2-3 зууны өмнөх шиг хэв маягаар амьдарч, мартагнал, санаашрал, туйлшралын нийгмийн хандлага дор өөрийнхөө хэмжээгээр алхам бүрээр, сайнаар ба муугаар ардчилагдаж байлаа. Мэдээж хэрэг энэ нь ардчиллынх уу эсвэл аль нэгэн лидерийн буянаар уу ямар ч байсан **СОНГУУЛЬ, СОНГОЛТ** гэдэг үгсийн тусламжтайгаар бага ч гэсэн хөрөнгө оруулалт хөдөөд хаялага болон очиж харанхуйг гийгүүлэх наран лугаа болж байсан цаг саяхан. Нийгмийн энэхүү үзэгдэл хөдөөд хүндээр тусаж иргэд хаялагын төв болсон Улаанбаатар, түүний ойролцоох газрууд, Эрдэнэт, Дарханд ихээхэн хэмжээгээр төвлөрч ёстой хүний ЗУД гээч үзэгдэл бий болжээ. Энэ талаар тоон мэдээлэл толгой эргэм их тул дурьдахыг хүссэнгүй.

Хөдөөгийн хөгжил ба соёлын шок...

Биднийг ийнхүү хот руу төвлөрч байх зуур хөгжил гээч зүйл хот хөдөөгийн ялгаа багасч улам бүр таатай боломж, амгалан амьдралын нөхцөл, хөх тэнгэр, байгаль эх дэлхийтэйгээ харьцах боломж, урт уужим амьсгалах агаар, эрх бүрэн хангагдаж цаашлаад төсвийнхний цалин пүнлүү нэмэгдэж, малын гаралтай бүх зүйл үнэд орж малчид мөнгөжиж, тариаланчид шинжлэх ухаанчаар хүнсний ногоо, тариалалтаа хийх зэрэг боломж нэмэгдэж дэлхийн хөгжилтэй нэгэн зэрэг алхах орчин нөхцөл нь бүрджээ.

Даяаршил, мэдээлэл, харилцаа холбооны хөгжил, түүхт өмч хувьчлал, малыг малчдад өгсөн зэрэг нийгэмд гарсан өөрчлөлт нь малчдын оюун санаа, сэтгэлгээний хэв загвар, ахуй амьдралд гүн гүнзгий өөрчлөлт оруулсан. Эдүгээ хөдөөгийн иргэдийн амьдралд шинэ хэрэгцээ (цахилгаан, телевиз, машин техник, хүнсний шинэ хэрэглээ, мэдээлэл авах, гэх мэт) дэлхий нийтийн хөгжлийн үр шимийг хүртэж байна. Цаашлаад сум бүрт гар утас, малчин айл бүхэнд өнөөгийн телевизийн олон суваг, солонгос олон ангит кино, садар самуун, элдэв алаан хядаан, хулгай дээрэм, ядаргаанд оруулам реклам зэргийг зарим аймгийн болон хотын завгүй нэгнээс ч илүү мэдээлэл авч тархиа угаалгасаар л байна.

Бид эргээд түүхээ харья. Социалист системийн буянаар монголчууд хэрхэн соёлжиж, хүн төрхөө олж байсныг түүхийн эрээн хуудсанд мартахын аргагүйгээр дурайтал бичсэн байдаг. Харин 90-ээд онд сум, аймгууд тог цахилгаангүй, харилцаа холбооны хөгжил үгүй, зам тээвэр, худалдаа наймаа, хөрөнгө оруулалт үндсэндээ зогсонги байсаар 10 гаруй жил болсон. Энэ хугацаанд нөгөө орос ах нарын нөлөөгөөр соёлжиж байсан бидний цөөхөн монголчууд ялангуяа хөдөө гэсэн тодотголтой иргэд,

малчид үндсэндээ хөгжил гэдэг зүйлээс тасарсан, мартагнасан, орхигдсон нь түүхэн үнэн.

Ийм байдалд байсан хөдөөгийн иргэд эдүгээгийн гар утас, интернет, телевизийн олон суваг, айл бүрийн гадаа сойгдох машин, мотоцикл, бараа таваар цаашлаад хөдөөгийн орфлэймээр гангарах цаг мөч хөгжлийг бас дэвшлийг тодорхойлж байгаа нь маргашгүй үнэн. Мэдээж энэ бол бидний мөрөөдөл бас үнэлж баршгүй сайн зүйл.

Харин үүний хажуугаар бидний нүдний өмнө болж байгаа зүйл бол яах аргагүй соёлын шок юм. Хөдөөгийн залуус чухам соёлыг мэдэрч бас шоконд орсоор л байна. Соёлын шок гэж чухам юугаа хэлээд байнаа ... ямарч хүн шинэ соёлд дасан зохицох явцдаа төрөл бүрийн эвгүй байдалд орох нь элбэг байдаг. Гэхдээ эцэст нь дасан зохицох дадал туршлагатай болсон байдаг. Зарим хүн шинэ соёлд маш амархан дасан зохицож байхад зарим нь хэдэн сар, жилийг зарцуулах нь ч бий. Зарим хүн шинэ соёлд дасан зохицох орчноо мэдрэхдээ өөрт ашигтай байдлаар хүлээн авч, дадаж заншдаг бол зарим нь ядаргаа, стрест орох, нийгмийн сөрөг үзэгдлийг тэр соёлоос олж авч улмаар хүнд байдалд ордог болохыг судлаачид тогтоожээ.

Түүгээр ч барахгүй нөгөө олон ангит телевизийн өрнөлт, халуухан, адал явдалт бүхий кино, түүнээс санаа аван амьдрал өрнүүлэгч бүтэлгүйчүүдийн хэрэг явдал хөдөөд ихээхэн газар авч байгаа талаар хууль, цагдаагийн байгууллагын мэдээлэл бас л нэг соёлын шокын сөрөг илрэл нь биз. Мөн соёлыг хүлээн авахын хирээр өртөг, үнэ бүхий үйлчилгээ бараа материал нь тэднийг бусдаас дутахгүй гэсэн монгол араншингаар санхүүгийн хүндрэлд өөрсдийгөө оруулж байгаа жишээ хөдөөд мөн л хаа сайгүй тааралдаж байна. Хөдөөд харьцангуй хурдан

соёлжиж, өөрөөр хэлбэл хөгжиж байхад түүнийг дагасан үйлчилгээг манай орон нутагт байхгүй байгаа нь соёлын шок буюу эерэг зүйлээс гарах сөрөг дагаврыг бий болгох үндэс болж байх шиг. Ийнхүү хөдөөгийн иргэд их бага ямар нэг хэмжээгээр соёлын шок гэдэг зүйлд өртөж байгаа нь бид хөдөөд аливаа зүйлийг хийхдээ тухайн технологи, инновацийг дагасан цогц үйлчилгээ, чанар, мэдээлэл боломжуудыг бий болгох, зохион байгуулалт хийх шаардлагатайг харуулж байна. Сүүлийн үед Улаанбаатарын иргэд суурьшмал иргэний соёлгүй, ухамсаргүй байна гэсэн асуудал хүчтэй газар авч байгаа бол бид хөдөөд энэ алдаагаа дахин давтахгүйн тулд соёлын шокоос хамгаалах дархлаажуулалтыг бий болгох шаардлага зүй ёсоор урган гарч ирж байна.

Хөдөөд соёлын шок ... үргэлжилсээр л байна. Энд дархлаа хэрэгтэй ... гэхдээ хөдөөд хөгжил хурдтайгаар түгэж хүн амьдрах нөхцөл боломжууд хором бүрт нэмэгдсээр байна.

### Хөдөөгийн ядуурал ба түүний хүчин зүйлүүд

Монголын хүн амын 36 хувийг ядуус эзэлдэг. Ядуурлын тухай үндсэн ойлголтууд улс үндэстэн бүрт өөр байдаг. Нэгдсэн Үндэсний Байгууллагын хүрээнд хүн ам зүйн үзүүлэлт, эрүүл мэнд, хүнсний хэрэглээ, орон сууц, хөдөлмөрийн нөхцөл, хүн амын орлого ба зарлага, хэрэглээний үнэ, тээврийн хэрэгсэл, нийгмийн хангамж, амралтын зохион байгуулалт зэргийг үнэлэн ядуурлын түвшинг тодорхойлдог байна. Харин манай орны хувьд хот хөдөөгийн ялгаа, өрхийн ам бүлийн тоо, өрхийн орлого, зарлага, хэрэглээ, ажлын байрны хүрэлцээ гээд хэдхэн үзүүлэлт ядуурлын хэмжүүр болдог хэмээн судалгааны нэгэн тайлангаас уншсан. Харин сүүлийн 6 жилд

монголын эдийн засагт нэлээд өөрчлөлтүүд гарав. Ядуурлын тухай хэдэн тоон мэдээлэл болон судалгаанаас иш татвал:

Амьжиргааны доод шугамыг үндэслэн ядуурлын хамралтын хүрээг тодорхойлоход нийт хүн амын 36.1 хувь нь ядуу байгаа ба ядуурал өргөн тархсан үзэгдэл болоод байна.

Хөдөөтэй харьцуулахад хот суурин газруудад ядуурал харьцангуй доогуур байгаа бөгөөд хотод 30 хувь, хөдөөд 43 хувь байна. Ядуурлын түвшин Улаанбаатар хотод хамгийн бага ба ядуу 9 хүний 5 нь сумын төв хөдөөд амьдарч байна.<sup>1</sup> Эндээс үзэхэд хөдөөд ядуурал хамгийн их тархсан нийгмийн бодит үзэгдэл болсон нь тодорхой байна.

Дээрх судалгаанаас харахад ядуурлын гүнзгийрэлт ба мэдрэмжийн индекс мөн л хөдөөд хотоос өндөр байна. Ядуурлын түвшинг газар зүйн байрлалаар нь авч үзэхэд Баруун бүсэд хүн амын бараг талаас илүү хувь нь, Хангайн бүсийн хүн амын бараг тавны 2 нь, Төвийн болон Зүүн бүсийн хүн амын гуравны нэг орчим хувь нь ядуу байна.<sup>2</sup> Ядуурал хөдөөд өндөр байгаагаас гадна газар зүйн байршил, хотжилт, дэд бүтэц, зам харгуй зэрэг олон хүчин зүйлээс улбаатай болох нь харагдаж байна.

Хүний эрхийн үндэсний комиссийн хийсэн судалгаанд “Нэн ядуу иргэдийн эрхийн төлөв байдал туйлын хангалтгүй байна. Ядуурлыг бууруулах, ядуу, нэн ядуу иргэдэд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ зэрэг асуудлыг зөвхөн нэг, хоёр яам, агентлагийн ажил мэтээр хаяж орхигдуулах явдал өнөө хүртэл явж иржээ. Гэтэл 3 хүн тутмын нэг нь ядуу, 5 хүн тутмын нэг нь нэн ядуу байдалд амьдарч байгаа өнөө үед эргээд эдийн засаг, нийгмийн хөгжлийг сааруулах, байгаль орчныг зүй зохисгүй ашиглах, гэмт хэрэг, хүчирхийлэл, тэгш

1 УСГ, 2004. “Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр

2 УСГ, 2004. “Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгаа” тайлан, хуудас 17.судалгаа” тайлан, хуудас 2.

энэ зохицуулалт хангалтгүй юм. Ядуурлын асуудал зүйн зохистой өсөлтийг бууруулах гэх мэт

бус байдлыг нэмэгдүүлэх, хүн амын олон сөрөг зүйлийг дагуулж байна”<sup>3</sup> хэмээн дүгнэсэн нь ихээхэн оновчтой дүгнэлт болжээ.

Мөн нэгэн судлаач үзэхдээ “Дэлхийн дундажтай жишихэд монголын хүн амын маш цөөн хэсэг нь амьжиргаагаараа зохих түвшинд дүйцэж, дийлэнхи олонхи нь ядуу байна. Хүн амын 30-40 хувь нь ядуу гэх нэг түвшин ярьдаг боловч үнэлэх хэмжүүрийг нь тооцдог амьжиргааны доод түвшин гэдэг ойлголт өөрөө бас үлэмж бага түвшинд тогтоогдсон байдаг” хэмээн дүгнэсэн байна. Эндээс харахад ямар ч байсан ядуурал гээч зүйл нийгмийг бүрэн бүрхсэн бөгөөд тодорхой бодит үнэлгээ өгөхөд хэцүү болох нь ойлгогдож байна. Бид тооны хойноос уралдах биш чанарыг шүтэх нь хойшдын бодлого тодорхойлоход чухал үүрэгтэй байх болов уу.

Энэ бүхний эцэст эдүгээ хүртэл бид ядуурал гэдэг зүйлтэй дайн хүртэл зарлаж тэмцсэн боловч бодит байдал хэвээрээ. Эцсийн дүгнэлт бол өнгөрсөн 17 жил ядуурлын шинж тэмдэгтэй тэмцэж ирснээс биш жинхэнэ бодит зүйлээ тойрсоор яваа юм уу гэсэн бодол энэхүү асуултын эцсийн цэгийг бүрдүүллээ.

Ядуурлын хүрээнд ард иргэд, гэр бүлийн гишүүдийг цөхрөл, найдваргүй орчин, өрөвдөлтэй байдал, айдас нэгтгэгдэж байдаг нь хөдөөд, малчин иргэдтэй ажилласан ажлын мань туршилгаас харагдаж байсныг энд онцлон тэмдэглэж байна.

Ядуурлын шинж тэмдгүүдийг бууруулснаар ядууралтай тэмцэж байгаа хэрэг биш харин ядууралд нөлөөлж буй хүчин зүйлсийн эсрэг тэмцсэнээ ядуурлыг бууруулна. Магадгүй

энэ нь монголчуудын ядууралтай тэмцэхэд гаргадаг байсан түүхэн алдаа байх. Ядуурал нь нийгмийн тулгамдсан асуудал учраас гарах арга замыг оршин байгаа нийгмээс хайх ёстой. Макро эдийн засгийн түвшинд дотоодын нийт бүтээгдэхүүн бага, үндэсний үйлдвэрлэл, мөнгөний хомсдол зэрэг нь ядуурлыг илэрхийлэхээс бус ядуурлын шинж тэмдэг биш юм.

Тэгвэл ядуурал гэх зүйлийг багасгах арга зам нь доорх таван том хүчин зүйлийг нийгмээс ор мөргүй арилгах, үгүй ядаж түүнийг багасгах ёстой гэж үзэж байна.

**Ядуурлын хүчин зүйлд үл тоомсорлох байдал, өвчин, хайхрамжгүй байх, шударга бус байдал, бусдаас хамааралтай байх зэрэг нь орно.**

*Үл тоомсорлох байдал:* Мэдээлэл хомс байснаас эсвэл мэдлэг бага байгаагаас үл тоомсорлох байдал үүсдэг. Гэвч энэ нь боловсролгүй, ухаан муутай байхаас ялгаатай юм. Харамсалтай нь үл тоомсорлох, боловсролгүй, ухаан муутай байх зэргийг хүмүүс нэг утгатай мэтээр ойлгодог. Хэнд ямар хэрэгцээ байгааг олж харах нь чухал. Олон түмнийг хөгжүүлэхээр бодлого хэрэгжүүлж байгаа олон хүмүүс асуудлын шийдвэр нь боловсролд байна гэж үздэг. Гэвч тариачин хүнд Шекспирийн “Ромео Жульета” зохиолд гол 2 баатар нь нас бараад төгсдөгийг мэдэхийн оронд тухайн нутагт ямар үр үндэслэж чадах, ямар нь эс чадах талаар мэдэж байвал илүү ашигтай.

Орчин үед ямар ч хүн хэрэгцээтэй цагт, чухал үедээ мэдээллээ зөв авч, ашиглаж чадаагүйгээс маш их хохирол амсдаг. Энэ нь эцсийн бүлэгт ядуурах нэгэн хүчин зүйл болж байна. Манай нийгэмд дээд боловсрол, дипломны цуглуулга болсон залуучууд хоногоос хоногт ядуурч байгаа нь чухам л үл тоомсорлох байдлыг бий болгож байна.

<sup>3</sup> Б.Хишигсайхан, 2003. “Нэн ядуу иргэдийн эрхийн төлөв байдал” судалгааны тайлан, Улаанбаатар

**Өвчин, зовлон:** Өвчин нь зовлон, үхлийг дагуулахаас гадна ядуурлын нэг гол хүчин зүйл болдог. Эрүүл биед саруул ухаан оршдогийн адил эрүүл байснаар ядуурлыг арилгахад шууд нөлөөлж чадна. Урьдчилан сэргийлэх нь сүүлд анагаахаас (эмчлэхээс) хялбар байдаг гэсэн эрүүл ахуйн үндсэн онол байдаг. Энэ дүрэм бидэнд бас үйлчилнэ. Хүн ам эрүүл байхад эдийн засаг ч эрүүл байна. Өвчтэй хүмүүс байгаа бол тэдний эрүүл мэндэд хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй. Мөн сэтгэлийн өвчин сүүлийн жилүүдэд нийгмийг үнэхээр хямрааж байна. Сэтгэл гутрал, стресс, дарамт шахалт, өөдрөг бус үзэл зэрэг нь дорд байх, ядуу байх нийгмийн сэтгэл зүйг хүчтэй бий болгож байна.

**Хайхрамжгүй байдал:** Төр засгийн үйлчилгээ хүн рүү чиглэсэн биш, эдийн засаг руу, дэд бүтэц рүү хандсан хандлага нь хүнээ хайхрамжгүй байлгах үндэслэл болж байна. Төр гэж хэрвээ байдаг бол цаана нь хүн л байх нь зүйн хэрэг. Харин тэр төр-хүн нь бусад хүндээ, олон нийтдээ хайхрамжгүй хандах нь ядуурлыг дэвэргэх үндсэн том хүчин зүйл юм. Бодит жишээ манай нийгмээр дүүрэн олдох болно. Жил жилийн төсвийн үзүүлэлтэд барилга, эрчим хүч, дэд бүтцийн асуудалд ихээхэн хандаж эцсийн бүлэгт нөгөө хүн гэсэн зүйлээ төр мартаж эсвэл хайхрамжгүй байдлаар хандах субъект болгож байна. Хүндээ шууд бус, бусад зүйлээр дамжуулан хүргэх гэсэн бодлого, үйл хэрэг эцэст нь хайхрамжгүй байдал буюу ядуурлыг бий болгох гол хүчин зүйл болж байна.

**Шудрага бус явдал:** Олон нийтийн үйл ажиллагаа, тэдний авьяас чадварт зориулагдсан баялгуудыг хэн нэгэн эрх бүхий хүний хувийн халаасанд орох нь өнөө үед зөвхөн ёс журмын асуудал биш болжээ. Ингэж сүрдүүлж аваад шамшигдуулж байгаа мөнгөний хэмжээ нь ард олонд зориулагдсан баялгын багаахан хэмжээ

гэвэл бас л биш. Хэрэв бид ядуурлыг үүсгээд буй нэгнээ шагнаад, золиос болсон нэгнээ шийтгээд байвал бидний энэ андуу ойлголт нь ядуурлыг ихэсгэсэн хэвээр байх нь зүйн хэрэг. Шамшигдаж завшигдсан мөнгө улсаас гарч гадаадын ямар нэг улсын банканд (жишээ нь Швецарь) орвол улсын эдийн засагт ямарч тус дэм болохгүйгээр барахгүй энэ нь зөвхөн улс орноо гадаадын бараа бүтээгдэхүүнээр дүүргэх юмуу эсвэл гадаад улс орнуудын банкуудад тусалж буй хэрэг юм. Саяхан нэгэн бизнесмэний яриагаар шудрага бус байдал, хээл хахуульд өгсөн мөнгөөс болж бид иргэдэд нэг ширхэг бүтээгдэхүүн дээр 200 төгрөг нэмж өгдөг гээд өдөр тутмын нэгэн сонинд ярилцлага өгчихсөн байх юм. Энэ чухам юу гэсэн үг вэ?

**Бусдаас хамааралтай байх:** Хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авсаар байх, түүнийг ирнэ хэмээн найдсаар байхад гарах үр дагавруудыг энд хэлж байна. Аюул гамшиг тохиолдсоны дараа тодорхой богино хугацааны хүмүүнлэгийн тусламж нь амьд үлдэж, аврагдахад зайлшгүй хэрэгтэй байж болох юм. Харин урт хугацаанд авах тусламж хүлээн авагчийн болзошгүй үхэл, оршин тогтнож буй ядуурлыг нэмэгдүүлж ч болох юм. Энд нэг хэсэг нь маш ядуу, сул дорой, нөгөө хэсэг нь нэгэндээ тусалж чадахааргүй болсон бол гадны тусламж дэмжлэг зайлшгүй хэрэгтэй гэсэн хандлага, итгэл үнэмшил манай оронд арчигдахааргүй гүн ул мөрөө үлдээжээ. Бид бусдаас хараат байна гэдэг нь ямагт ядуурлыг дуудаж байгаа хэрэг. 2007 оны намраас ганцхан орос улсаас хараат, бензин түлшний үнэ өдрөөс өдөрт өсөж, өнөө хэдэн ханш муутай төгрөгийг минь багасгасаар л байна.

Хараат байдлын тухай түүх манай оронд хангалттай бий. Иймээс бид ямар ч зүйлээс хараат бус, чөлөөт сэтгэлгээгээр ажил хэрэгт хандаасай гэж үзэж байна.

**Товчоор дүгнэхүй:** Нийгмийн ямарч өөрчлөлтийн үед бид бүхэн “Дэлхийн хэмжээнд сэтгэж, улс орон, орон нутгийн хэмжээнд хийх” хэрэгтэй болж байна. Ядуурлын 5 том хүчин зүйлс нь бодит хэрэг дээрээ манай нийгмийн соёлын үнэт зүйлсэд гүн гүнзгий шигдэж тархсан байна. Гэвч аж төрөх энэ ахархан хугацаанд үүний төлөө юуг ч хийж чадахгүй хэмээн бидний зарим нь андуу боддог байж болох юм. Гэвч асуудлыг олон өнцгөөс харж байж арай илүү шийдлийг олох нь дамжиггүй хэмээн ойлгоном.